

**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН “АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨРИЙГ 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022.06.06

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт
1	2	3	4	5
<b>Нэг.Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшлыг хууль тогтоомжийн дагуу олгох.</b>				
1.1.	Улсын их хурал, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөх.	Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоож, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Тухай бүр	Засаг даргын Тамгын газрын 2022 оны 01 дүгээр сарын 1-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар нийт албан хаагчдын цалин санг баталсан.  Хэрэгжилт-100
1.2.	Төрийн албан хаагчдад олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ажилласан жилийг харгалзан төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан тогтоож олгох.	Хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Жилдээ	2022 онд 1 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар тооцож олгож байна.  Хэрэгжилт-100
1.3.	Гачигдалтай болон тэмдэглэлт үйл явдал, арга хэмжээний үед олгох буцалтгүй мөнгөн тусламжийн хэмжээг тогтоож олгож байх.	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд оруулж буцалтгүй мөнгөн тусламжийн хэмжээг тогтоосон байна.	Жилдээ	Байгууллагын дотоод журмын 8.4-д заасны дагуу 3 албан хаагчдын өргөдлийн дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. Нийт 300,000 төгрөг  Хэрэгжилт-100
1.4.	Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх асуудлыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөр шийдвэрлүүлэх.	Зэрэг дэв нэмэгдүүлэх асуудлыг Төрийн албаны салбар зөвлөлд шуурхай хандаж шийдвэрлүүлнэ.	Жилдээ	Төрийн захиргааны 6 албан хаагчид бүгд түр томилгоотой тул зэрэг дэв нэмэх боломжгүй байна. Төрийн захиргааны 1 албан хаагчийн зэрэг дэвийг 2023 оны төсвийн төсөлд тусгуулахаар бэлтгэж байна.

				Хэрэгжилт-30
1.5.	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшууллын асуудлыг шийдвэрлэх.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас бүтэн жилээр дүгнэж урамшууллын асуудлыг шийдвэрлэнэ.	2,4-р улирал	Төрийн үйлчилгээний албан хаагчид сар бүр 25 хувийн ур чадварыг бүрэн олгож ажиллаж байна. Нийт 6 албан хаагчдад 1-5 дугаар сарын байдлаар 4,614,147 төгрөгийг олгосон байна.  Хэрэгжилт-100
1.6.	Албан хаагчдад сар бүр хоолны зардлыг олгох	Батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэнэ.	Сар бүр	Засаг даргын Тамгын газрын нэг албан хаагч хоолны зардалд өдрийн 1900 төгрөг авдаг. 16 албан хаагчдад 1-5 дугаар сар хүртэл 2,965,900 төгрөгийг хоолны зардал олгосон байна.  Хэрэгжилт-100
1.7.	Албан хаагчдын гэр бүлд шинээр хүүхэд мэндлэх, үрчлэн авах тохиолдолд мөнгөн дэмжлэг олгоно.	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт хангагдсан байна.	Тухай бүр	Албан хаагчдын гэр бүлд шинээр хүүхэд мэндлээгүй байна.  Хэрэгжилт-ХБ
<b>Хоёр. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл бололцоогоор хангах</b>				
2.1.	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, скайнер, хувилагч болон бусад техник хэрэгсэлээр хангах.	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирч шаардагдах техник хэрэгслэлээр бүрэн хангагдаж тухайн үеийн тавигдаж байгаа шаардлагад нийцүүлэн ажлаа явуулах бололцоотой болно.	Тухай бүр	Албан хаагчид өөрсдийн гэр интернетийн модемийг хэрэглэдэг байсныг болиулж мобикомын шилэн кабелд холбогдсон бөгөөд, шинээр ЗДТГазрын төсвийн хөрөнгөөр 1 албан хаагчид 2,999,000 төгрөгийн зөөврийн компьютер худалдан авч ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажилласан. Түүнчлэн иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв шинээр байгуулж, 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Нээлттэй тендер шалгаруулж “Эргэл Хийц”ХХК-тай Иргэдэд үйлчлэх төвийн тоног төхөрөмж нийлүүлэх 33,963,000 төгрөгийн гэрээг байгуулсан байна.

				Хэрэгжилт-30
2.2.	Албан үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үед унаагаар үйлчлэх.	Шаардлагатай үед шатахууны талноор хангана.	Жилдээ	Албан ажлаар аймгийн төв болон хөдөө орон нутгаар томилолтоор явахад шатахуун болон унаагаар бүрэн хангаж ажилласан. Нийт-6 албан хаагчдад 1,344,800 төгрөгийн томилолт олгосон байна.  Хэрэгжилт-70
2.3.	Ажлын байрны нөхцлийг сайжруулах зорилгоор 1 албан хаагчийн өрөөг засварлан 3 хаалгыг шинээр солих.	Ажлын байрны нөхцөл сайжирсан байна.	Жилдээ	2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Засаг дарга, Халамжийн мэргэжилтэн нарын өрөөний хаалгыг сольж шинээр хаалгыг угсарч суурилуулсан байна. Мөн ХАА-н мэргэжилтэний өрөөний засвар, Онцгойн штабын өрөөг засварласан байна. Нийт 3 хаалгыг шинэчилсэн. Нийт-1,389,850  Хэрэгжилт- 70 хувь
2.4.	Албан хаагчдын ажлын байрны завсарлагааны дасгал хөдөлгөөнийг цагийн хуваарийн дагуу тогтмол хийж хэвших.	Ажлын байрны завсарлагааны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн байна.	Жилдээ	"Илүүдэл жингүй-Эртэч монгол" аяны хүрээнд 11:00-11:15 цагийн хооронд ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж байна.  Хэрэгжилт-100
<b>Гурав. Орон сууцны нөхцлөө сайжруулах, орон байраар хангагдахад нь хөрөнгө санхүүгийн болон зохих туслалцаа, дэмжлэг үзүүлэх</b>				
3.1.	Төрийн албан хаагчийг амьдрах орчин нөхцөлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх, албан хаагчдыг амьдрах орон сууцаар хангах.	Төрийн албан хаагчийн амьдрах орчин нөхцөл зохих хэмжээгээр дээшилнэ.	Жилдээ	Суманд ажиллахаар ирсэн нийт 14 албан хаагчийг байгууллагын орон сууцаар хангаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Энэ онд нийт 1 төрийн албан хаагч ажиллахаар шинээр ирснийг төрийн албан хаагч нарын байранд орон сууцаар хангаад байна.

				Хэрэгжилт-100
<b>Дөрөв. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх</b>				
4.1.	Төрийн албан хаагчдыг хагас бүтэн жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж шаардлагатай хүмүүст эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх, амралт сувилалд явахад нь дэмжлэг үзүүлэх.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах асуудал сайжирч өвчлөл буурсан байна. Албан хаагчдад шаардлагатай тохиолдолд мөнгөн тусламж үзүүлсэн байна.	1,3-р улиралд	1 албан хаагч нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх тэтгэмж хүссэн өргөдөл гаргасаны дагуу Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 300,000 төгрөгийн тэтгэмж олгон нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд оруулсан байна. Нийт-300,000  Хэрэгжилт-100
4.2.	Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт нь албан тушаалын цалинг, биед нь гэмтэл учруулсан тохиолдолд эмчилгээний зардлыг буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгох.	Шаардлагатай тохиолдолд мөнгөн тусламж үзүүлнэ.	1,3-р улиралд	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган мөрдөн ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар албан хаагчийн амь нас хохирсон асуудал үүсээгүй байна.  Хэрэгжилт-100
4.3.	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад зориулсан чийрэгжүүлэлт, бялдаржуулах танхимд тогтмол хичээлэхэд, таатай нөхцөл бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлэх.	Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх асуудал дээшилсэн байна.	2-р улиралд	Албан хаагчдад зориулж бялдаржуулах, чийрэгжүүлэх танхимд тогтмол хичээлэхэд таатай нөхцөл бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа “XS”-клубын Аэробек, Степ дасгалуудтай жин хасаж галбиржуулах хөтөлбөрт албан хаагчдаа бүрэн хамруулсан. Ингэснээр төрийн албан хаагчид бие бялдраа тогтмол чийрэгжүүлж хөгжүүлэх бүрэн боломжтой болсон.  Хэрэгжилт-70
4.4.	Албан хаагчдыг, жилд 2 удаа бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулах.	Бүх албан хаагчид хамрагдсан байна.	2,4-р улиралд	Баянтал сумын фитнес клубын багш Б.Мөнгөнцэцэг багшаар түвшин тогтоох сорилд хамрагдаж бие бялдрын сорилын анкетийг хөтлүүлсэн байна.  Хэрэгжилт-30 хувь
<b>Тав. Албан хаагч өөрөө өвдөж эмчлүүлж, сувилуулахад зохих дэмжлэг тусалцаа үзүүлэх</b>				

5.1.	Тухайн албан хаагчийн сарын цалингаас илүү төлбөртэй эмчилгээг зайлшгүй хийлгэх болсон тохиолдолд эмнэлэгийн тодорхойлолт, эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг харгалзан тухайн ажилтны эмчилгээний зардалд нь албан тушаалын нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй мөнгөн тусламж олгож, дэмжлэг үзүүлэх.	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд оруулж буцалтгүй мөнгөн тусламжийн хэмжээг тогтоосон байна.	Тухай бүр	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.4-т заасны дагуу 1 албан хаагчид эмчилгээний зардал болох 300,000 төгрөгийн буцалтгүй тусламжийн хэмжээг тогтоосон  Хэрэгжилт-100
<b>Зургаа. Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах</b>				
6.1.	Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж жилд хоёроос доошгүй удаа идэвхтэй амралт зохион байгуулах.	Эко аялалыг зохион байгуулсан байна.	2-р улиралд	Ерөнхий сайдын санаачилсан “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяны хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 16 ний бямба гариг 5 байгууллагын 11 авто машинтай 54 хүний бүрэлдэхүүнтэй Чойрын богд уул уруу нутгийн түүх, соёлын дурсгалт газруудтай танилцаж, байгууллагуудын албан хаагчдыг идэвхжүүлэх, эрүүл амьдралын зөв дадлыг бий болгох зорилгоор аялал, арга хэмжээ, нийтийн дасгал хөдөлгөөнийг зохион байгууллаа. Энэ аяны хүрээнд байгууллагын албан хаагчид өглөөний алхалтыг тогтмол хийж хэвшсэн байна. Нийт-514,800 төгрөг  Хэрэгжилт-100
6.2.	Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор долоо хоног бүрийн Лхагва гарагт Спорт зааланд тоглох, Даваа, Пүрэв, Баасан гарагт чийрэгжүүлэлтийн танхимд хичээллэх.	Цагийн хуваарийн дагуу хичээллэсэн байна.	7 хоног бүр	Сумын Засаг даргын 2021 оны А/152 албан тоотор сумын бүх байгууллага, аж ахуй нэгжүүдэд “Спортын хамтлаг” байгуулагдсан. ЗДТГ-ын хувьд байгууллагын спортын хамтлагийг Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 17 өдрийн А/13 дугаар тушаалаар томилогсон. Ажлын байрны дасгал хөдөлгөөн, өглөөний гүйлт зөв хооллолтын 1 өдрийн сургалтад хамруулах зэрэг ажлыг зохион байгуулсан.

				<p>Хэвийн горимд шилжиж төрийн албан хаагчид бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гарагт Спорт зааланд тоглож бялдаржуулах танхимд хичээллэж байна.</p> <p>Хэрэгжилт-70</p>
--	--	--	--	--

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

*М.Бодино*

М.БОДЬГЭРЭЛ

**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН “АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,  
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨРИЙГ 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

2022.06.06

Д/д	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн үнэлгээ				Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
			100%	70%	30%	0%		
1	6	19	11	4	3	-	1	81,6

ТАЙЛАН ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

В.ГАНТУЯА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.БОДЬГЭРЭЛ